



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 18 өдөр

Дугаар A/86

Алтай хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 27 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2022 оны аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх "Цахимжуулалт" төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2."Цахимжуулалт" төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулж хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл)-т үүрэг болгосугай.


3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Алтанзагас)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны
02 дугаар сарын 18 ны өдрийн 1/26 дугаар
захирамжийн хавсралт



**ЦАХИМЖУУЛАЛТ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ХИЙГДЭХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хийгдэх ажлын нэр	Төсөвт өртөг / төгрөг /
1	Говь-Алтай аймгийн цахим үйлчилгээний нэгдсэн платформ, Бүрэн Динамик вэб байгуулах	60,000,000
2	Цахим үйлчилгээний нэгдсэн платформ байгуулахад шаардагдах киоск төхөөрөмж худалдан авах	161,000,000
3	Говь-Алтай аймгийн төрийн үйлчилгээний цахим шилжилттэй холбоотой сургалт, сурталчилгаа зохион байгуулах	19,326,200
4	Цахим үйлчилгээний нэгдсэн платформ байгуулахад шаардагдах видео, live-ын тоног төхөөрөмж	16,430,000
5	Хэвлэлийн тоног төхөөрөмж, программ хангамж	5,055,800
6	Оффисийн тоног төхөөрөмж худалдан авах	18,600,000
7	Видео хурлын тоног төхөөрөмж худалдан авах	19,588,000
	Дүн	300,000,000

__оОо__